# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 17 өдөр Дугаар А/553 Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай" 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Онгийн голын байнгын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Хяналтын постод 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хоол хүнс, түлээний зардалд зарцуулах 1,304,000 (нэг сая гурван зуун дөрвөн мянга) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

011101269

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2020 оны 12
дугаар сарын 17-ны өдрийн А/553 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

| д/д | Бараа материалын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Онгийн голын постод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хоолны мөнгө | 6 хүн | 17 хоног | 12000 | 1,224,000 |
| 2 | Мод | шуудай | 10 | 8000 | 80,000 |
| Нийт дүн | | | | | 1,304,000 |

-оОо-